

**Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн  
ХАМТАРСАН МЭДЭЭЛЭЛ**

**Өмнөговь аймаг  
Ханбогд сум**

**2017 оны 11-р сарын 27**

Ханбогд сумын Гурван талт зөвлөл 2017 оны 05 дугаар сарын 09-ны өдөр Малчдын гомдол барагдуулах гэрээ 1, 2-ийг харилцан зөвшөөрч гарын үсэг зуран баталгаажуулсан билээ. ГТЗ<sup>1</sup> энэ өдрөөс эхлэн эдгээр гэрээнд заасан хийхээр тохирсон ажлын хэрэгжилтийг хангахын төлөө ажиллаж байна. Зөвлөлийн хурлыг 9, 11-р саруудад хуралдуулж Гэрээнд тохирсон ажлын хэрэгжилтийн байдлыг хэлэлцэж, ажлын хэрэгжилтийг хангахад шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авлаа. Зарим ажлыг хэрэгжүүлэхэд тулгарч буй бодитой нөхцөл шалтгааны улмаас хэрэгжих хугацааг талууд харилцан тохирч хойшлуулсан болно. Энэхүү хамтарсан мэдээллээр гэрээ зурснаас хойшхи 6 сарын хугацаанд хийхээр тохирсон ажлын хэрэгжилтийн байдлыг тоймлон нийтэд хүргэж байна.

*Бэлчээр усны чиглэлээр*

Ханбогд суманд бэлчээр усны хангамжийг сайжруулах чиглэлээр хийхээр тохирсон ажлуудын хэрэгжилт төлөвлөсний дагуу урагшилж байна. Эдгээрийн нэг болох Ханбогд сумын Бэлчээрийн удирдлагыг сайжруулахад чиглэсэн “Бэлчээр Эрдэнэ” төсөл хэрэгжиж байна. Төслийн хүрээнд бэлчээрийн судалгаа хийгдэж дууссан. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах ажил хийгдэж байна. Энэ төслийн хүрээнд 2018 онд бэлчээр ашиглалтыг сайжруулах зорилгоор малчдын бүлэг байгуулан ажиллахаар төлөвлөж байна.

Усны чиглэлээр төлөвлөсөн ажлын нэг болох Гүний хоолой орчмын шүүрэлттэй цооногуудыг мэргэжлийн байгууллагын хяналтан дор бөглөж дуусгалаа Мөн Галбын Говьд байрлалтай оргилдог 2 цооногийг бэлчээрийн болон зэрлэг ан амьтны усан хангамжийн зориулалтаар ашиглуулах зорилгоор тохижуулан орон нутагт хүлээлгэн өглөө. Үүнээс гадна Гүний хоолой, Галбын говьд байрладаг ОТ-н усны хайгуулын цооногуудаас орон нутгийн малчдын бэлчээрийн усан хангамжийн зориулалтаар ашиглах боломжтой 12 цооногийг Ханбогд суманд хүлээлгэж өгөх ажлуудыг хэрэгжүүллээ. Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилго бүхий Бэлчээрийн доорхи усны геофизикийн буюу цэгэн өрөмдлөг хайгуул хийх судалгааны дүнд үндэслэн шинээр худаг гаргах, хуучин гар худаг болон инженерийн хийцтэй худаг засварлах төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

*Нөхөн олговрын чиглэлээр*

Зөвлөлөөр тохирсон тодорхой шалгуур хангасан малчин өрхүүдийн нэхэмжлэлийг хэлэлцэж шийдэх үүрэг бүхий Нөхөн олговрын нэхэмжлэлийн хороог байгууллаа. Хорооны үйл ажиллагааны журмыг хамтран боловсруулж, журмын дагуу сар бүрийн 25-нд хуралдаж малчдын нэхэмжлэлийг хэлэлцэн шийдвэрлэж байна. Хорооны эхний хурлуудаар нөлөөллийн бүс, нөхөн олговрын багцтай холбоотой асуудлыг харилцан тохирсон.

---

<sup>1</sup> Ханбогд сумын Сумын удирдлага, Малчдын төлөөлөгчид болон Оюу толгой компанийн хамтарсан Гурван талт зөвлөл (ГТЗ) нь талуудын маргааныг шийдвэрлэх зорилгоор Харилцан ойлголцлын санамж бичигт зурсны дагуу 2015 оны 6 сарын 8-нд албан ёсоор байгуулагдсан болно. ГТЗ-ийн үйл ажиллагааг Эрх зүйн Нийцэл Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений газраас (ЭЗНХЗОГ) чиглүүлж байна.

2017 оны 11 сарын 27-ны байдлаар нийт 112 нэхэмжлэлийг Хороо хүлээн авлаа. Хороо ёс зүйтэй шударга ажиллаж, малчин өрхийн нэхэмжлэл бүрээр шийдвэр гаргах үүрэгтэй. Энэ үүргээ хэрэгжүүлэхийн тулд нэхэмжлэлүүд, түүнд хавсарч ирсэн нотлох баримтыг нягтлан шалгаж, гурван талын төлөөлөл бүхий Ажлын хэсэг байгуулан, нэхэмжлэлийг хэлэлцэн шийдвэр гаргаж байна. 11 сарын 27-ны байдлаар нөхөн олговор олгох шалгуурт бүрэн нийцсэн 5 өрхийн нэхэмжлэлд нөхөн олговор олгох шийдвэр гаргаж холбогдох хариуг малчин өрхөд мэдэгдээд байна. Шалгуур хангаагүй 35 нэхэмжлэлд татгалзсан шийдвэр гаргаж мэдэгдлээ.

Өрхийн нөхөн олговроос гадна Ханбогд сумын бүх малчин өрхүүдэд үр өгөөжөө өгөх зорилготой нийтийн нөхөн олговрын хүрээнд хэрэгжүүлэх ажлуудыг Гэрээнд тусгасан. Эдгээрийн нэг болох магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуульд суралцаж буй малчдын оюутан хүүхдүүдийн сургалтын тэтгэлэг олгох ажлыг Оюу толгой компани хариуцан зохион байгуулж, 20 оюутанд сургалтын тэтгэлэг олголоо. Эдгээр 20 оюутанд тэтгэлэг олгох ажлыг ирэх 4 жилийн хугацаанд Ханбогдын сумын “Хөгжлийн хэлхээ” төрийн бус байгууллага гүйцэтгэнэ. Нийтдээ Ханбогд сумын малчин өрхийн оюутан хүүхдийн 23 өргөдөл хүсэлтийг хүлээн авсан. Их дээд сургуулийн биш буюу техник мэргэжлийн сургуулийн оюутны нэг хүсэлт хасагдсан. 2 оюутан жилийн чөлөө авсан болон хэлний бэлтгэлд суралцах шалтгаанаар энэ жилийн тэтгэлгээс хасагдсан бөгөөд дараа жилээс эхлэн тэтгэлгээ авах боломжтой юм. Тэтгэлэг олгох ёслолын ажиллагааг 11 сарын 3-нд Улаанбаатар хотод зохион байгууллаа.

Малчдын гомдол барагдуулах гэрээнд нийтийн нөхөн олговрын хүрээнд Тогтвортой амьжиргааг дэмжих чиглэлийн 10 төслийг тодорхойлон гаргаж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Зарим төслүүдийг чиглэл үйл ажиллагааны хувьд нэгтгэж 7 төсөл болгож өөрчлөөд байна. Төслийн тооцоог хийх, төслийг боловсруулах, хэрэгжүүлэгч нэгжийг тодруулах байгуулах зэрэг төлөвлөлт зохион байгуулалтын ажлууд хийгдэж байна. Төслүүдэд нийтийн нөхөн олговрын хүрээнд хийгдэж буй үйл ажиллагаанд давуу боломж олгохоор тохирсон “зорилтот бүлэг” буюу 2004, 2011 оны нөлөөллийн бүсийн дөнгөж гадна үлдсэн өрхүүд, шууд бус нөлөөлөлд өртсөн малчин өрхүүдийг давуу байдлаар хамруулах юм.

#### Ундайн голын гольдрол өөрчлөлтийн чиглэлээр

Оюу толгой компанийн уурхайн лицензтэй талбайд (УЛТ) байрлах нутгийн иргэдийн шүтдэг Бор Овоог хөндөхгүйн тулд уурхайн хаягдал чулуулгын овоолгын зураг төслийг өөрчлөн боловсруулж Бор Овоог хөндөхгүй хэвээр үлдээхээр боллоо. Бор Овоогийн шинэ задгайн байршлыг орон нутгийн малчидтай зөвлөлдөн тохирсон бөгөөд Бор Овоогийн шинэ задгайг ургамалжуулах талбайг хамтран төлөвлөсөн юм. Оюу толгой компани төлөвлөсний дагуу ургамалжуулалтын талбайг хашаалан ажиллаж байна.

Говийн бүсийн экологийн нөхцөлийг хамгаалах, тэр дундаа Ханбогд сумын төв орчимд байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах, хөрс ургамал, усны нөөцийг хамгаалахад хувь нэмрээ оруулах, Говь нутагт амьдарч байгаа нутгийн иргэд, малчид, залуу үеийг эрдэм шинжилгээний байгууллагын судалгаа шинжилгээний үр дүн, аж ахуйн нэгж болон уул уурхайн компаний тэргүүн туршлагыг НУТГИЙН УХААНТАЙ хослуулан сумын төв орчмыг цэцэрлэгжүүлэх зорилготой “Говийн төгөл” төсөл хэрэгжиж байна.

УЛТ доторхи Ундай голын дагууд буюу ажилчдын кемпийн баруун талын сайран дээрээс карьер авсан газар, дулааны станц руу ордог замын хойд талд цөөрмүүд үүсч байсан асуудлыг шийдвэрлэлээ. Өөрөөр хэлбэл, тухайн газруудад Ундайн голыг дахин чөлөөтэй урсгахын тулд ГТЗ дээр тохирсон арга хэмжээнүүдийг авснаар үерийн усны урсгал цөөрөм үүсэхгүй урсан өнгөрөх нөхцөл бүрдсэн бөгөөд 2017 оны 8 болсон үерийн үеэр малчдын төлөөлөл газар дээр ажиглалт хийж, үр дүнг хяналаа.

Зөвлөл хийхээр тохирсон ажил нэг бүрийн хэрэгжилтийн байдлыг улирал бүрийн сүүлийн сарын 25-нд тайлан байдлаар бэлтгэн гаргаж хэлэлцэж байхаар төлөвлөөд байна. Хийхээр тохирсон ажлын хэрэгжилтийн явцын мэдээллийг тухай бүрд нь иргэд олон нийтэд тоймлон хүргэх болно. Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Зөвлөлд хандана уу.

Зөвлөлийн хурлуудад Эрх зүйн Нийцэл Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений газрын (ЭЗНХЗОГ)<sup>2</sup> чиглүүлэгч гэрээний хэрэгжилтэнд хяналт хийх үүргээ гүйцэтгэж, ажиглагчаар оролцож байна.

### **Ханбогд сумын Гурван талт зөвлөл**

---

<sup>2</sup> Эрх зүйн Нийцэл Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений Газар (ЭЗНХЗОГ) бол Дэлхийн Банкны Группын Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) болон Олон Талын Хөрөнгө Оруулалтын Баталгааны Байгууллагатай (ОТХОББ) холбоотой асуудлаар хөндлөнгийн хараат бус хариуцлагын механизмын үйлчилгээ үзүүлдэг хараат бус, бие даасан байгууллага болно.